



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/437

Мандалговь

Ахмадын байгууллагын 30 жилийн ойг
тохиолдуулан дэмжлэг үзүүлэх тухай

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 14 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн ахмадын байгууллага үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойн баярын хурал, арга хэмжээний зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Арга хэмжээнд зарцуулагдах 1,652,262 (Нэг сая зургаан зуун тавин хоёр мянга хоёр зуун жаран хоёр) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

438010364